



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 02 өдөр

Дугаар 1/151

Номгон

“Хүүхдэд ээлтэй орон нутаг” стратеги
боловсруулах ажлын хэсэг
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйл 29.2 дахь заалт, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16.4.1 дэхь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран хэрэгжүүлж буй “Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөр”-ийн тогтвортой байдлыг хангах зорилгоор “Хүүхдэд ээлтэй орон нутаг” стратеги боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Д.Энхжаргал- Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: Б.Наранбаяр- Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

В.Наранчимэг- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Н.Энхжаргал- Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Ц.Энхтөр- Боловсрол соёл урлагийн газрын дарга

Б.Алтантуяа- Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын Халамжийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Б.Содончимэг- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Хүүхдийн эрхийн улсын байцаагч

М.Саранцэцэг- Аймгийн Цагдаагийн газрын хүүхдийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн


А.Орхончимэг- Дэлхийн зөн ОУБ-ын Баянхонгор- 2 хөтөлбөрийн менежер

Ц.Баярмаа- Монголын хуульчдын холбооны Баянхонгор аймаг дахь зохицуулагч

Нарийн бичгийн дарга: Н.Мэндбаяр- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга

2.Хөтөлбөрийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан боловсруулж ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэхийг ажлын хэсгийн дарга (Д.Энхжаргал)- д үүрэг болгосугай.

3.Ажлын хэсгийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, уул уурхай, нийгмийн салбар хариуцсан орлогч дарга (Г.Энхбаяр)- д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

